



72

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 470

Улаанбаатар хот

Г Бага насны хүүхдийг А, Д аминдэмээр
хангах зааврыг шинэчлэх тухай

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Засгийн газрын 2009 оны 32 дугаар тогтоолд заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. "Хүнсний аюулгүй байдал" үндэсний хөтөлбөр, "Эх, хүүхдийг бичил тэжээлийн дутлаас сэргийлэх стратеги"-ийн хэрэгжүүлэх, хүүхдийг хоол тэжээлийн архаг дутлаас сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх зорилгоор өндөр тунт А, Д аминдэмийг захиалах, худалдан авах, түгээх, уулгах зааврыг нэгдүгээр, А, Д аминдэмийн хэрэглээг бүртгэх, мэдээлэх, суртацилгаа, хяналт хийх зааврыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Бага насны хүүхдийг А, Д аминдэмээр хангах арга хэмжээг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (Ө.Ганчимэг)-д даалгасугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Я.Буянжаргал)-т даалгасугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын (хуучин нэрээр) 2000 оны 74 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



002395

Эрүүл мэндийн сайдын
2013 оны 12 дугаар сарын
~~12~~ өдрийн ~~470~~ дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

73

Өндөр тунт А, Д аминдэмийг захиалах, худалдан авах, түгээх, уулгах заавар

Нэг. Өндөр тунт А, Д аминдэмийг /витамин/ захиалах, худалдан авах

1.1 Аймгийн түвшинд:

1.1.1. Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эрхлэгч, ахлах эмч нар зорилтот бүлгийн хүн амын бүтэн жилийн шаардлагатай А, Д аминдэмийн захиалгыг маягт 1 ба 2-ын дагуу (хүүхдийн тоог 5%-иар илүү тооцно, А аминдэмийг 6-59 сартай хүүхэд жилд 2 удаа ууна гэж тооцно, Д аминдэмийг 0-36 сартай хүүхэд жилд 12 удаа ууна гэж тооцно) гаргаж, аймгийн эрүүл мэндийн газар (ЭМГ)-т жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний дотор хүргүүлнэ.

1.1.2. Аймгийн ЭМГ захиалгыг нэгтгэн, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (НЭМҮТ) -ийн асуудал хариуцсан мэргэжилтэнд 11 дүгээр сарын 15-ны дотор хүргүүлнэ.

1.2 Нийслэлийн түвшинд:

1.2.1. Өрхийн эрүүл мэндийн төвийн ахлагч нар зорилтот бүлгийн хүн амын бүтэн жилийн шаардлагатай А, Д аминдэмийн захиалгыг маягт 1 ба 2-ын дагуу (хүүхдийн тоог 5%-иар илүү тооцно, А аминдэмийг 6-59 сартай хүүхэд жилд 2 удаа ууна гэж тооцно, Д аминдэмийг 0-36 сартай хүүхэд жилд 12 удаа ууна гэж тооцно) гаргаж, дүүргийн эрүүл мэндийн нэгдэл (ЭМН)-д 11 дүгээр сарын 01-ний дотор хүргүүлнэ. Дүүргийн ЭМН захиалгыг нэгтгэн нийслэлийн ЭМГ-ын холбогдох мэргэжилтэнд 11 дүгээр сарын 10-ны дотор хүргүүлнэ.

1.2.2. Нийслэлийн ЭМГ захиалгыг нэгтгэн, НЭМҮТ-ийн Хоол судлалын албанад 11 дүгээр сарын 15-ны дотор хүргүүлнэ.

1.3 Эрүүл мэндийн яамны түвшинд:

1.3.1. Аймаг, нийслэлийн ЭМГ-аас ирүүлсэн захиалгыг НЭМҮТ-ийн холбогдох мэргэжилтэн нэгтгэж, үндэсний хэмжээнд шаарддагдах өндөр тунт А, Д аминдэмийн нэгдсэн захиалгыг хийж Эрүүл мэндийн яам (ЭМЯ)-ны Нийгмийн эрүүл мэндийн чиг үүрэг бүхий хэлтэст 11 дүгээр сарын 30-ны дотор хүргүүлнэ.

1.3.2. ЭМЯ нь холбогдох журмын дагуу үнэлгээний хороог байгуулан тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан эм ханган нийлүүллэх байгууллагуудын (شاардлага хангасан бол гадаад тендер зарлаж болно) дунд тендер зарлаж, шаардлагатай өндөр тунт А, Д аминдэмийн ханган нийлүүлэлтийг зохицуулна.

34

Маят 1: Өндөр түнт Аамнүүдийн захилалыг маят

(Өндөр түнт А аминдэм уувал зохих 6-11 ба 12-59 сартай хүүхдийн тоо + 5%)
(Нийт хүүхдийн тоо х 2)

Тайлбар: Нийт хүүхдийн тоо-Хэрэгчээт Амийн дэмшигийн тоо-

Маягт 2: Өндөр тунт Д аминдээмийг захиалах маягт

Тайлбар: Нийт хүүхдийн тоо = (Өндөр тунт Д аминдэм уувал зохих 0-36 сартай хүүхдийн тоо + 5%)

Хэрэгцээт Д аминдэмийн тоо = (Нийт хүүхдийн тоо x 12)

Хоёр. Өндөр тунт А, Д аминдэмийг түгээх

- 2.1. Тендерт ялсан хуулийн этгээд нь ЭМЯ-тай гэрээ байгуулан (гэрээнд А, Д аминдэмийн мэдээлэл, сурталчилгааг багтааж болно) ажиллаж, өндөр тунт А, Д аминдэмийг гэрээний дагуу ханган нийлүүлэх, хадгалах, аймаг, нийслэлийн ЭМГ, эрүүл мэндийн нэгдэл (ЭМН)-үүдэд түгээх ажлыг гүйцэтгэнэ.
 - 2.2. Өндөр тунт А, Д аминдэмийг захиалгын тоонд түшиглэн Эрүүл мэндийн сайдын тушаалын дагуу эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилна.
 - 2.3. Өндөр тунт А, Д аминдэмийг аймаг, нийслэлийн ЭМГ комисс байгуулан, акт үйлдэн хүлээн авч ЭМГ-ын даргын тушаалын дагуу дүүргийн ЭМН, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хуваарилна.
 - 2.4. Өндөр тунт А, Д аминдэмийн нөөцийг сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмийн санд MNS 5260 : 2011 стандартын дагуу хадгална.
 - 2.5. Өндөр тунт Д аминдэмийг 3 хүртэлх насны хүүхдэд, өндөр тунт А аминдэмийг 6-59 сартай хүүхдэд тус тус хугацаанд нь түгээх, уулгах үйл ажиллагааг сум, өрхийн эрүүл мэндийн төвийн ахлагч, эмнэлгийн ажилтнууд нь сайтар сургагдсан эрүүл мэндийн сайн дурын идэвхтнүүд, эрүүл мэндийн дэмжлэг үзүүлэх бүлгийн идэвхтнүүдийн оролцоотойгоор гүйцэтгэнэ.

Гурав. Бага насын хүүхдэд өндөр тунт А, Д аминдэмийг уулгах

3.1. 6-59 сартай хүүхдэд өндөр тунт А аминдэмийг уулгах заавар

3.1.1. А аминдэмийг сум, өрхийн эрүүл мэндийн төвд эмнэлгийн ажилтан 6-11 сартай хүүхдэд 100000 ОУН тунгаар, 12-59 сартай хүүхдэд 200000 ОУН тунгаар жил бүрийн 5 ба 11 дүгээр саруудад 1 ширхэгээр уулгана (хүснэгтийн дагуу).

3.1.2. Өндөр тунт А аминдэмийг уулгаж байгаа тохиолдолд бусад хэлбэрийн А аминдэм болон найрлагандаа А аминдэм агуулсан бэлдмэл, холимогийг давхардуулан уулгахгүй байвал зохино.

Өндөр тунт А аминдэмийг уулгах хүүхдийн насын бүлэг ба тун

№	Нас	100000 ОУН (Цэнхэр капсултай)	200000 ОУН (Улаан капсултай)	Уух хугацаа
1	6-11 сар	1 капсул	$\frac{1}{2}$ капсул ¹	Жил бүрийн 5 ба 11 дүгээр сард
2	12-59 сар ²	2 капсул ³	1 капсул	

3.1.3. Өндөр тунт А аминдэмийг уулгах үед анхаарах зүйлс:

- Тухайн бэлдмэлийн үзүүрийг нь хайчлан аманд нь дусаах,
- 6-11 сартай хүүхдэд 200000 ОУН аминдэмийг уулгах тохиолдолд зөвхөн 3 дуслыг уулгах¹,
- Хүүхэд сүүлийн 30 хоногийн дотор өндөр тунтай А аминдэм уугаагүй байх,
- Өрх, сумын эмнэлгийн ажилтны хяналтан дор уулгах,
- А аминдэм уусан тохиолдол бүрийг "Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр" (ӨЭ-1)-ийн Хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжилт ба хооллолтын талаарх тэмдэглэлд заавал (+) тэмдгээр тэмдэглэнэ.

3.2. Гурав хүртэлх насын хүүхдэд өндөр тунт Д аминдэмийг уулгах заавар

3.2.1. Д аминдэмийн дутлаас сэргийлэх зорилгоор 3 хүртэлх насын (0-36 сартай буюу 2 нас 11 сар 29 хоногтой) хүүхдэд 50000 ОУН тунтай D₂ (Ergocalciferol) аминдэмийг сум, өрхийн эрүүл мэндийн төвд эрүүл мэндийн ажилтан сар бүр 1 удаа, жилд нийт 12 ширхэгийг уулгана.

3.2.2. Рахитаас сэргийлэх зорилгоор D₂ аминдэмийг 50000 ОУН тунгаар уулгаж байгаа тохиолдолд бусад хэлбэрийн Д аминдэм болон найрлагандаа Д аминдэм агуулсан бэлдмэл, холимогийг давхардуулан уулгахгүй байвал зохино.

¹ 100000 ОУН тунтай А аминдэмийн хангалт хэрэлцээгий тохиолдолд 200000 ОУН тунтай А аминдэмийг 6-11 сартай хэрэгдэд уулгах үед.

² 59 сар гэдэг нь 5 хүртэлх нас буюу 4 нас 11 сар 29 хоногтойг хэлнэ.

³ 200000 ОУН тунтай А аминдэмийн хангалт хэрэлцээгий тохиолдолд 100000 ОУН тунтай А аминдэмийг 12-59 сартай хэрэгдэд уулгах үед.

3.2.3. Θндөр тунт Д аминдэмийг уулгах үед анхаарах зүйлс:

- Хүүхдэд ракитийн шинж тэмдэг илрээгүй байх,
- Θрх, сумын эмнэлгийн ажилтны хяналтан дор уулгах,
- Д аминдэм уусан тохиолдол бүрийг "Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр" (ӨЭ-1)-ийн Хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжилт ба хооллолтын талаарх тэмдэглэлд заавал (+) тэмдгээр тэмдэглэнэ.

3.3. Гурав хүртэлх насын хүүхдэд ердийн тунт Д₃ аминдэмийг уулгах заавар

3.3.1. Рахитаас сэргийлэх зорилгоор D₂ (Ergocalciferol) аминдэмийг 50000 ОУН тунгаар уугаагүй тохиолдолд өдөр тутмын бага тунтай D₃ (Cholecalciferol) аминдэмийг уулгана.

3.3.2. Хүүхдийн эцэг, эх нь өдөр тутмын бага тунтай D₃ (Cholecalciferol) аминдэмийг өөрсдөө худалдан авч, хүүхдэдээ тогтмол уулгах боломжтой байвал D₃ аминдэмийн урьдчилан сэргийлэх тунг сум, өрхийн эмчийн зааврын дагуу тохируулан өөрсдөө гэрээр хүүхдэд уулгана.

Өдөр тутмын бага тунтай D₃ аминдэмийг хүүхдэд уулгах
урьдчилан сэргийлэх тунгийн дээд хязгаар

№	Насны бүлэг	Өдрийн тунгийн дээд хязгаар
1.	0-6 сар	1000 ОУН
2.	7-12 сар	1500 ОУН
3.	1-3 нас	2000 ОУН

Тайлбар: Өдөр тутмын бага тунт D₃ аминдэм Аквадетрим (Холекальциферол, аминдэм D₃) нь 1 дусалдаа 500 ОУН D₃ аминдэм агуулдаг. Иймд 1-3 настай хүүхдэд 6 долоо хоногийн турш өдөр бүр 4 дуслыг өгнө. Өдөрт 4 дуслаас илүүг өгч болохгүй.

3.3.3. Рахитаас сэргийлэх зорилгоор D₃ аминдэмийг өдөр тутмын тунгаар уулгаж байгаа тохиолдолд бусад хэлбэрийн D аминдэм болон найрлагандаа D аминдэм агуулсан бэлдмэл, холимогийг давхардуулан уулгахгүй байвал зохино.

3.3.4. Өдөр тутмын бага тунтай D₃ аминдэмийг хүүхдэд уулгахад анхаарах зүйлс:

- D₃ аминдэмийг насанд нь тохирсон тунгаар 6 долоо хоногийн турш өдөр бүр уулгаж, 3 сар завсарлан, дахин 6 долоо хоногийн турш уулгах гэсэн дарааллаар уулгах,
- Хүүхдэд ракитийн шинж тэмдэг илрээгүй байх,
- Θрх, сумын эмчийн хяналтан дор уулгах,
- D аминдэм уусан тохиолдол бүрийг "Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр" (ӨЭ-1)-ийн Хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжилт ба хооллолтын талаарх тэмдэглэлд заавал (+) тэмдгээр тэмдэглэнэ.

Эрүүл мэндийн сайдын
2013 оны 12 дугаар сарын
12 өдрийн 470 дугаар
тушаалын 2 дугаар хавсралт

**Өндөр тунт А, Д аминдэмийн хэрэглээг бүртгэх, мэдээлэх, сурталчилгаа,
хяналт хийх заавар**

Нэг. Өндөр тунт А, Д аминдэмийн хэрэглээг бүртгэх

Эрүүл мэндийн ажилтан, сайн дурын идэвхтнүүд нь бага насны хүүхдийн сар бүрийн хоол тэжээлийн байдлыг үнэлэх явцад А, Д аминдэмийг бага насны хүүхдэд түгээх, уулгах, бүртгэх үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

1.1. Сумын эрүүл мэндийн төв болон аймаг, нийслэлийн дүүрэг, хороодын өрхийн эрүүл мэндийн төвийн эрүүл мэндийн ажилтнууд, сайн дурын идэвхтнүүд нь:

- a). 6-59 сартай хүүхдэд А аминдэмийг 5 ба 11 дүгээр сард,
- b). 3 хүртэлх насны хүүхдэд 50 000 ОУН тунтай Д₂ аминдэмийг сар бүр эсвэл,
- v). 3 хүртэлх насны хүүхдэд өдөр тутмын бага тунтай Д₃ аминдэмийг 6 долоо хоногийн туршид уулгасан эсэх тухай мэдээллийг “Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр” (ӨЭ-1)-ийн хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжилт ба хооллолтын талаарх тэмдэглэл болон хүүхдийн өсөлт, хөгжлийн бүртгэлийн маягт ӨЭ-3б-д (+ эсвэл -) тэмдгээр тэмдэглэж, бүртгэнэ.

1.2. Д аминдэмийг Д₂ эсвэл Д₃ гэж ялгалгүйгээр Д аминдэм уусан гэж нэг л янзаар бүртгэнэ.

Хоёр. Өндөр тунт А, Д аминдэмийн хэрэглээг мэдээлэх

2.1. Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр (ӨЭ-1) болон хүүхдийн өсөлт ба хөгжлийн бүртгэлийн маягт (ӨЭ-3а, б)-ыг үндэслэн сум, өрхийн эрүүл мэндийн төвөөс А, Д аминдэмийн түгээлт, хэрэглээний дүнт тухайн сарын сүүлийн өдрөөр тасалбар болгон Хүүхдийн өсөлт ба хөгжлийн сарын мэдээ тайлангийн маягт (хуучин нэрээр МТ 201.5) -ын дагуу тайланг гаргаж, аймаг, дүүргийн ЭМГ, ЭМН-ийн Статистик мэдээллийн албанад дараа сарын 1-ний дотор багтаан хүргүүлнэ.

2.2. Нийслэлийн дүүргийн ЭМН-ийн Статистик мэдээллийн албанаас нэгтгэсэн тайланг файл хэлбэрээр тухайн сарын 2-ны дотор багтаан Нийслэлийн ЭМГ-ын Мэдээлэл, хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс (МХШҮХ)-т хүргүүлнэ.

2.3. Аймаг, нийслэлийн ЭМГ-ын МХШҮХ нь Статистик мэдээллийн албанаас нэгтгэсэн тайланг файл хэлбэрээр тухайн сарын 3-ны дотор багтаан НЭМУТ-ийн асуудал хариуцсан мэргэжилтэнд хүргүүлнэ.

2.4. НЭМҮТ-ийн асуудал хариуцсан мэргэжилтэн үндэсний хэмжээнд НЭГТГЭСЕН тайланг, түүнд хийсэн дүн шинжилгээ ба асуудлыг шийдвэрлэх саналын хамтаар тухайн сарын 8-ны дотор багтаан ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн чиг үүрэг бүхий хэлтэст, холбогдох мэргэжилтэнд хүргүүлнэ.

2.5. ЭМЯ аминдэм бичил тэжээлийн дутлаас сэргийлэх, бууруулах бодлогын хүрээнд, НЭМҮТ-өөс ирүүлсэн саналд тулгуурлан танилцуулга хийх, шаардлагатай багц үйл ажиллагааг төлөвлөх, хамтрагч сонирхогч талуудыг оролцуулах, дэмжлэг хүсэх, хариуцагч байгууллагад албан тоотоор санал, үүрэг, шаардлага хүргүүлэх, шийдвэр гаргах, үнэлэх, дэмжих зэрэг ажлыг хариуцна.

Гурав. Сурталчилгаа, хяналт хийх

3.1. Өндөр тунт А, Д аминдэм, өдөр тутмын бага тунт Д аминдэмийг урьдчилан сэргийлэх тунгаар бага насны хүүхдэд уулгаж, хэрэглээг сайжруулах, мэдээ, тайлан ирүүлэх, хяналт үнэлгээ хийхтэй холбогдох сургалт, мэдээлэл сурталчилгааны арга хэмжээг НЭМҮТ-ийн Хоол судлалын алба боловсруулж, гүйцэтгэлийг хариуцна.

3.2. Өндөр тунт А, Д аминдэмийн захиалга, түгээлт, хадгалалт, хангалт, мэдээлэх үйл ажиллагааны хяналт үнэлгээг аймаг, нийслэлийн ЭМГ-ын болон Хяналтын асуудал эрхэлсэн газраас эрүүл мэндийн анхан шатны байгууллагад хийгдэх хяналт үнэлгээтэй хавсруулан ЭМГ-ын статистик мэдээлэл, хоол тэжээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн эсвэл хүүхдийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн нарын оролцоотойгоор хийнэ.

3.3. Өндөр тунт А, Д аминдэмийн захиалга, түгээлт, хадгалалт, хангалт, мэдээлэх үйл ажиллагааны хяналт үнэлгээний ажлыг Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн мэргэжилтнүүдийн оролцсон баг жилд 1-2 удаа хийнэ.

3.4. Эрүүл мэндийн байгууллагууд нь өндөр тунт А, Д аминдэмийн захиалга, түгээлт, хадгалалт, хангалт, мэдээлэх, тайлагнах үйл ажиллагааны хяналт үнэлгээг дотоод хяналтын журамдаа тусган хэрэгжүүлнэ.